



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/89

Арвайхээр

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай  
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Баян-Өндөр, Баянгол, Бүрд, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Есөнзүйл, Төгрөг, Сант, Нарийнтээл, Хайрхандулаан, Тарагт, Уянга, Хужирт, Хархорин сумдын 127.7 мянган га бэлчээрт микробиологийн аргаар мэрэгч амьтантай тэмцэх ажлыг 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Сумдын бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх талбайн хэмжээ болон бактержуулсан будааны зардлын хуваарилалт, нийтийг хамарсан ажил үйлчилгээний зардлыг нэгдүгээр, бэлчээрийн хөнөөлт амьтантай тэмцэх ажилд аймгаас ажиллах алба хаагчдын зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд иргэд, малчид, малчдын бүлэг хоршоог хамруулж тэднийг мэрэгч устгалын гарын авлага, шаардлагатай техник хэрэгслээр хангаж, сургалт явуулах, бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дээрх ажлыг эхлүүлж, сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулж, мэрэгчтэй тэмцэх ажилд ажиллах хүчийг хөдөлмөр хамгаалалын хувцсаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), уг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус даалгасугай.

5. Мэрэгч амьтантай тэмцэхэд зарцуулагдах 3.019.260 (гурван сая арван есөн мянга хоёр зуун жар) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдлийг бууруулах арга хэжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100189

D:My Doc. Zahiramj. Zasag darga



Аймгийн Засаг даргын 2020 оны 03  
дугаар сарын 05 ны өдрийн 189 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

СУМДЫН БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ АМЬТАНТАЙ  
ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

д/д	Сумын нэр	Сумаас олгосон санхүүжилт /мянган төгрөг/	Сумдын авах бактержуулсан будаа /тонн/	Аймгаас хувиарлах бактержуулсан будаа /тонн/	Улсын төсвөөс олгосон бактержуулсан будаа /тонн/	Нийт бактержуулсан будаа /тонн/	Бэлчээрийн хөнөөлт мэргэгчтэй тэмцэх талбай /мянга га-аар/	Нийтийг хамарсан ажил үйлчилгээний зардлаас цалин /төгрөг/	Нийтийг хамарсан ажил үйлчилгээний зардлаас хөдөлмөр хамгааллын зардал /төгрөг/
1	Баян-Өндөр	46000.0	9.2	4.3	26.5	40	20.0	14,000,000	1000000
2	Баянгол	6000.0	1.2	1	3.8	6	3.0	2,100,000	150000
3	Бүрд	10000.0	2	1	5.7	8.7	4.3	3,045,000	217500
4	Гучин-Ус	2000.0	0.4	1.6	1	3	1.5	1,050,000	75000
5	Зүүнбаян-Улаан	5000.0	1	1	3	5	2.5	1,750,000	125000
6	Өлзийт	7500.0	1.5	1	4.5	7	3.5	2,450,000	175000
7	Есөнзүйл	5000.0	1	1	3	5	2.5	1,750,000	125000
8	Төгрөг	5000.0	1	1	3	5	2.5	1,750,000	125000
9	Сант	3000.0	0.6	1.4	2	4	2.0	1,400,000	100000
10	Нарийнтээл	1000.0	0.2	1.3	0.5	2	1.0	700,000	50000
11	Хайрхан дулаан	15000.0	3	1	8	12	6.0	4,200,000	300000
12	Тарагт	8000.0	1.6	1.4	4	7	3.5	2,450,000	175000
13	Уянга	5000.0	1	1	3	5	2.5	1,750,000	125000
14	Хужирт	10000.0	2	1	6	9	4.5	3,150,000	225000
15	Хархорин	10000.0	2	1	6	9	4.5	3,150,000	225000
		<b>138500.0</b>	<b>27.7</b>	<b>20.0</b>	<b>80.0</b>	<b>127.7</b>	<b>63.8</b>	<b>44,695,000</b>	<b>3192500</b>

Аймгийн Засаг даргын 2020 оны 03  
дугаар сарын 05 ны өдрийн 8789 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ АМЬТАНТАЙТЭМЦЭХ АЖИЛД  
АЙМГААС АЖИЛЛАХ АЛБА ХААГЧДЫН ЗАРДАЛ

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /100км-20 литр/	Нэг бүрийн үнэ /мянган төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
1	Аймгийн ажлын хэсгийн томилолт, шатахуун	хүн/өдөр	2 хүн/ 8 өдөр	18.0	288.0
		км	1858	2450	910.42
2	Хяналтын шатахууны зардал /3-н ажлын хэсэг 15 суманд ажиллана/	км	1858	2450	910.42
3	Мэрэгч устгалын ажлыг хүлээж авах ажлын хэсэг	км	1858	2450	910.42
	<b>Нийт</b>				<b>3.019.260</b>